

“БАГАНУУР” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛ

Огноо: 2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр
Хурал эхэлсэн цаг: 10:39

Улаанбаатар хот

“Багануур” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 10:39 цагт Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн байр (Хуучнаар Нийслэлийн засаг даргын тамгын газрын 1 дүгээр байр), 107 тоот хурлын танхимд хуралдав.

Хурлын ирц: Багануур ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал ирвэл зохих 20,974,360 ширхэг хувьцаа эзэмшигчдээс брокерын пүүсүүдээр дамжуулан хуралд 20,147,438 ширхэг хувьцааг төлөөлж 5 хүн итгэмжлэлээр, 2,530 ширхэг хувьцаа эзэмшигч 14 хүний өөрийн биеэр нийт 20,149,968 хувьцаа эзэмшигч оролцож хурал 96.07% ирцтэй хуралдав.

Хурал зохион байгуулсан комисс:

Д/д	Нэр	Албан тушаал
1	Ц.Уранбилэг	Хурал зохион байгуулах комиссын дарга, Захиргаа хүний нөөцийн хэлтсийн дарга
2	Г.Соёлмаа	Хурал зохион байгуулах комиссын нарийн бичиг, Төлөөлөгч (Хамтын ажиллагааны)
3	Я.Отгонбаатар	Хурал зохион байгуулах комиссын гишүүн, Бизнес төлөвлөлтийн хэлтсийн дарга
4	Ж.Болд-Эрдэнэ	Хурал зохион байгуулах комиссын гишүүн, Нягтлан бодох бүртгэлийн хэлтсийн дарга
5	Б.Эрдэнэтуяа	Хурал зохион байгуулах комиссын гишүүн, Гүйцэтгэх захирлын туслах
6	Б.Одгэрэл	Хурал зохион байгуулах комиссын гишүүн, Хуулийн зөвлөх
7	Б.Есөнцагаан	Хурал зохион байгуулах комиссын гишүүн, Хэвлэл мэдээллийн ажилтан
8	П.Нямхүү	Хурал зохион байгуулах комиссын гишүүн, Худалдааны менежер
9	Д.Дэлгэрсайхан	Хурал зохион байгуулах комиссын гишүүн, Комплайнсын ажилтан
10	Б.Гантулга	Хурал зохион байгуулах комиссын гишүүн, Бэлтгэн нийлүүлэгч, жолооч
11	Б.Хажидмаа	Тооллогын комиссын дарга, Дотоод хяналт, эрсдэлийн албаны дарга
12	Б.Наранцэцэг	Тооллогын комиссын гишүүн, Дотоод хяналт, эрсдэлийн албаны мэргэжилтэн

13	М.Дондогдулам	Тооллогын комиссын гишүүн, Дотоод хяналт, эрсдэлийн албаны мэргэжилтэн
----	---------------	--

ХУРАЛД ОРОЛЦСОН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ:

1. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Санхүүгийн нэгдсэн удирдлагын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Зоригтбат, Мэргэжлийн нэгдсэн зөвлөлийн зохицуулагч Л.Баярмандал, Ж.Ганбаатар
2. “Монголын нээлттэй коал корпораци” ХХК-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Э.Шижир, М.Отгонбаяр
3. Бусад хувьцаа эзэмшигч нар

ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ ТАНИЛЦУУЛСАН НЬ:

Хурлын хэлэлцэх асуудлуудаар дараах албан тушаалтнууд танилцуулга хийв.

Үүнд:

1. Т.Отгонболд – “Багануур” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч
2. Б.Наранбаатар – “Багануур” ХК-ийн Ерөнхий нягтлан бодогч
3. Я.Отгонбаатар - “Багануур” ХК-ийн Бизнес төлөвлөлтийн хэлтсийн дарга
4. П.Баттөр – Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга
5. Н.Зоригтсайхан – Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны дарга
6. Б.Гэрлээ – Төлөөлөн удирдах зөвлөлийн Нэр дэвшүүлэх хорооны дарга

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайланд өгсөн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
2. Компанийн 2025 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай
3. Ногдол ашиг хуваарилах эсэх талаар гарсан Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн танилцуулга
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025-2026 оны үйл ажиллагааны тайлангийн танилцуулга
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай
6. Компанийн өрийг хувьцаагаар солих тухай
7. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Б.Хажидмаа /Тооллогын комиссын дарга/: “Багануур ХК”-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийг танилцуулж, хуралдааны ирц бүрдсэн тул хурлыг хуралдуулахыг зөвшөөрч байна.

Ц.Зоригтбат (Хуралдаан даргалагч): Хурлыг нээж хэлэлцэх асуудал, хурлын дэг, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирлын тушаалыг тус, тус танилцуулав. Хэлэлцэх асуудлын нэгдүгээр асуудал болох компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлангийн танилцуулгыг “Багануур” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Т.Отгонболд танилцуулна уу.

Т.Отгонболд: /Багануур ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч/: Тэрээр тайлангийн эхэнд компанийн удирдлагын багийг танилцуулж, үргэлжлүүлэн компанийн 2025 оны үйл ажиллагааны тайланг танилцуулав. Үүнд: Тайлангийн хүрээнд компанийн үйл ажиллагаа, санхүүгийн үзүүлэлт, олборлолт, борлуулалт, стратегийн хэрэгжилт болон цаашдын хөгжлийн чиглэл, тулгамдаж буй асуудлууд гэсэн агуулгаар танилцуулгаа хийв. Компанийн нийт орлого 2025 онд 268.2 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгөөг 101.6 хувиар биелүүлсэн бол зардал 265.5 тэрбум төгрөг болж, татварын дараах цэвэр ашиг 1.9 тэрбум төгрөгт хүрсэн байна. Олборлолт, борлуулалт болон уулын ажлын гүйцэтгэлүүд төлөвлөгөөнөөс давж, 100–104 хувийн биелэлттэй ажилласан. Гэвч 1 тонн нүүрс олборлох өртөг 54,958 төгрөг, харин борлуулалтын үнэ 51,388 төгрөг байгаа тул тонн тутамд алдагдал хүлээж байгаа нь санхүүгийн үр дүнд сөргөөр нөлөөлж байгааг тэмдэглэсэн. Нэг тонн нүүрсний олборлолтын өртөг борлуулалтын үнээс өндөр байгаа нь компанийн алдагдлын гол шалтгаан болж байгааг талаар мөн компанийн нийт өр төлбөр 270 орчим тэрбум төгрөгт хүрсэн нь санхүүгийн ачаалал болж байгааг танилцуулж, өрийн бүтцийг сайжруулах, бууруулах чиглэлээр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлж байгааг мэдээлсэн. Түүнчлэн техник, тоног төхөөрөмжийн насжилт дунджаар 30 гаруй жил болсон нь үйлдвэрлэлийн найдвартай байдалд эрсдэл учруулж байгааг онцолж, техник шинэчлэл зайлшгүй шаардлагатай байгааг цаашид компанийн үйл ажиллагааг тогтвортой сайжруулахын тулд зардлыг бууруулах, бүтээмжийг нэмэгдүүлэх, өр төлбөрийг бууруулах, нүүрсний үнэ тарифын асуудлыг шийдвэрлэх зэрэг чиглэлд анхаарч ажиллах шаардлагатай байгааг илэрхийлсэн.

Тэрээр танилцуулгынхаа төгсгөлд компанийн үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдэд тодорхой ахиц гарсан ч гадаад болон бодлогын хүчин зүйлсээс шалтгаалсан хүндрэлүүд байсаар байгааг онцлон тэмдэглэж, цаашид нүүрсний үнэ тариф, өр төлбөрийн дарамт, хөрөнгө оруулалтын хомсдол зэрэг асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх шаардлагатайг дурдлаа.

Ж.Ганбаатар: Компанид тулгамдаж буй асуудлуудын талаар дурдаад, танилцуулгаас харахад ялангуяа цалингийн зардал ихээхэн өссөн байна. Түүнчлэн 2025 онд илүү цагийн зардал 8 тэрбум төгрөгт хүрсэн нь анхаарал татаж байна, саяхан цалингаа нэмэгдүүлсэн юм байна, цалин нэмэгдсэнтэй холбоотойгоор илүү цагийн зардал цаашид ч өсөх хандлагатай байгааг анхааруулж, үүнтэй холбогдуулан илүү цагийн ажлыг ямар үндэслэл, шаардлагаар олгож байгаа талаар, хэрэв шаардлагатай бол ажиллах хүчийг нэмэгдүүлэх нь илүү үр ашигтай байж болох эсэх талаар тодруулав.

Хишигсүрэн: Илүү цаг нэмэгдэх шалтгааныг тайлбарлаж, 4 ээлжийн ажиллагаа, хүний нөөцийн нөхцөл, техникийн эвдрэл зэрэг хүчин зүйлс нөлөөлж байгаа талаар тайлбар мэдээлэл өгөв.

Ц.Зоригтбат(Хуралдаан даргалагч): За дараагийн хүн асуултаа асууя. Өөр асуулттай хувьцаа эзэмшигч байна уу?

Хувьцаа эзэмшигч Цэдэнсодном: Багануурын уурхайд 1979 оны 12 сарын 25-аас хойш тэтгэвэрт гартлаа ажилласан. Өөрийн санал хэлье. Тэрээр компанийн одоогийн удирдлагын хэрэгжүүлж буй бодлогыг дэмжиж, холбогдох

байгууллагууд, тухайлбал “Эрдэнэс Монгол” ХК-ийн зүгээс бүх талаар дэмжлэг үзүүлэх нь зүйтэйг онцлов. Мөн “хөх нүүрс”-ний асуудлыг хөндөн, өмнөх жилүүдэд ч мөн яригдаж байсан энэхүү асуудлыг бодитоор хэрэгжүүлэх шаардлагатай байгааг тэмдэглэж, 2026 оны өвлийн бэлтгэл ажлын хүрээнд уг асуудлыг нэн тэргүүнд анхаарч шийдвэрлэхийг хүслээ. Түүнчлэн цаашид ТУЗ-ийн хараат бус гишүүдийн асуудлаар санал дэвшүүлэхээ илэрхийлэв.

Хувьцаа эзэмшигч Э.Шижир: Би Багануур хувьцаат компанийн жижиг хувьцаа эзэмшигчийн зүгээс Төлөөлөн удирдах зөвлөлд нь орж ажиллаж байгаа. Компанийн санхүүгийн хүндрэл, ялангуяа өр төлбөрийн асуудал тулгамдсан байгааг дурдаад, тус нөхцөл байдал нь Эрчим хүчний зохицуулах хорооноос эрчим хүчний нүүрсний үнийг тогтоохдоо хуулийн хүрээнээс давж, компанийн санал болгосон өртгөөс доогуур үнээр тогтоож ирсэн нь нөлөөлсөн байгаа талаар өөрийн байр сууриа илэрхийлэв. Тэрээр холбогдох хуулийн дагуу тус хороо нь зөвхөн үнийн тооцооллыг хянах үүрэгтэй байхад бодит байдал дээр үнийг шууд тогтоож байгаа нь тус хороо эрхээ хэтрүүлж байгааг дурдаад, энэ нь компаниудыг алдагдал, өрөнд оруулахад хүргэж байна гэж үзэж байгаагаа хэлэв. Иймд зөвхөн “Багануур” ХК бус, ижил нөхцөлд ажиллаж буй нүүрс нийлүүлэгч компаниудын асуудлыг цогцоор нь судалж, холбогдох байгууллагууд, ялангуяа “Эрдэнэс Монгол” ХК болон мэргэжлийн байгууллагууд анхаарч, бодлогын түвшинд шийдвэрлэх шаардлагатайг онцлон санал гаргав.

Хувьцаа эзэмшигч М.Отгонбаяр: Компанийн бизнес төлөвлөгөө болон техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-ийн хэрэгжилтийн мэдээлэл өгч, 2015 онд батлагдсан ТЭЗҮ-д нүүрсний үнийг үе шаттайгаар 58 мянган төгрөгт хүргэх шаардлагатайг тодорхойлсон боловч бодит байдал дээр үнийг 51 мянган төгрөгийн түвшинд барьж байгаа нь компанийн үйл ажиллагаа, мөнгөн урсгал, хөрөнгө оруулалтад сөргөөр нөлөөлж байгааг анхааруулж, мөн тухайн ТЭЗҮ-ийг мэргэжлийн байгууллагаар боловсруулсан байхад түүний тооцооллыг бодлогын түвшинд хангалттай авч үзэхгүй байгаад анхаарал хандуулж, компанийн зүгээс уг үндэслэлдээ тулгуурлан нүүрсний үнийг бодит түвшинд хүргэх асуудлыг идэвхтэй хөөцөлдөх шаардлагатайг тэмдэглэв. Энэ хүрээнд “Эрдэнэс Монгол” ХК-тай хамтран ажиллаж, холбогдох байгууллагуудаас дэмжлэг авах нь зүйтэйг дурдав. Түүнчлэн гадаад зах зээл, түүхий эд, шатахуун болон сэлбэг хэрэгслийн үнийн өсөлтөөс шалтгаалан нөхцөл байдал цаашид хүндрэх хандлагатай байгааг анхааруулж, уг асуудлыг яаралтай шийдвэрлэхгүй бол ирэх жилийн санхүүгийн үзүүлэлтэд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэйг санууллаа.

Ц.Зоригтбат (Хуралдаан даргалагч): “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Санхүүгийн нэгдсэн удирдлагын газарт томилогдон ажиллаж байна, Багануур болон Шивээ-Овоогийн уурхайнууд нь тус нэгдэлд анхлан нэгдсэн компаниуд бөгөөд хуримтлагдсан өр төлбөр өндөртэй, зөвхөн сүүлийн хэдэн жилд үүссэн асуудал биш талаар дурдаж, цаашид өр, зээлийн дарамтыг бууруулж, компанийг ашигтай ажиллуулах зорилтыг тавин ажиллаж байгааг онцлов. Мөн нүүрсний үнийн асуудлыг Засгийн газрын хэрэг эрхлэх газар, холбогдох яамд, Ерөнхий сайдын түвшинд тогтмол тавьж ирснийг тэмдэглээд, эрчим хүчний үнийг үе шаттайгаар чөлөөлөх чиглэлээр Эрчим хүчний яамнаас ажиллаж байгааг дурдав. Цаашид

энэ асуудлыг шийдвэрлэхэд идэвхтэй ажиллах бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан санал, дүгнэлтийг холбогдох байгууллагуудад уламжлан хүргэхээ илэрхийллээ.

Ө.Гэрэлт-Од (ТУЗ-ийн хараат бус гишүүн): Компанийн үйл ажиллагаанд өгсөн 80.1 хувийн гүйцэтгэлийн үнэлгээний бодит байдалд эргэлзэж буйгаа илэрхийлэв. Тэрээр өмнөх гүйцэтгэх захирлын үйл ажиллагааг хангалтгүй гэж үзэн удирдлагыг өөрчилсөн атлаа нийт гүйцэтгэлийг өндөр үнэлсэн нь хэр үндэслэлтэй болохыг тодруулах шаардлагатайг дурдав. Мөн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа нь тасралтгүй, залгамж холбоотой явагддаг тул гүйцэтгэлийг нэгдмэл байдлаар бодитоор үнэлэх нь чухал болохыг онцолж, Төлөөлөн удирдах зөвлөл болон “Эрдэнэс Монгол” ХХК-иас харьяа компанийн удирдлагын үнэлгээнд илүү бодитой хандахыг санал болгов. Түүнчлэн 2026 оны 4 дүгээр сар хүртэлх хугацаанд компанийн үйлдвэрлэл, хөдөлмөрийн аюулгүй байдал, техникийн гүйцэтгэл хэвийн, эрсдэлгүй явагдаж байгаа эсэхэд анхаарах шаардлагатайг дурдав. Иймд өгөгдсөн үнэлгээтэй холбоотойгоор Төлөөлөн удирдах зөвлөл болон “Эрдэнэс Монгол” ХХК-ийн зүгээс тодорхой тайлбар өгөхийг хүсэв.

Б.Гэрлээ(ТУЗ-ийн гишүүн): “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 97 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу үнэлгээ хийгдсэн болохыг дурдаад, үнэлгээний явцад эхний хоёр улиралд компанийн гүйцэтгэл хангалтгүй гэж дүгнэгдсэн бол гурав, дөрөвдүгээр улиралд гүйцэтгэл сайжирч, 70 гаруй хувийн үнэлгээтэй гарсан байна. Эхний байдлаар жилийн нийлбэр үнэлгээ 76 хувьтай ирсэн бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийн нэр дэвшүүлэх хорооноос холбогдох тайлбаруудыг компанийн зүгээс авч үзсэний үндсэн дээр уг үнэлгээг 80.1 хувь болгон нэмэгдүүлж, Төлөөлөн удирдах зөвлөлөөр Нэр дэвшүүлэх хорооны саналыг хэлэлцэн баталсан талаар тайлбар мэдээлэл өгөв.

Ц.Зоригтбат(Хуралдаан даргалагч): Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлантай холбогдуулан өөр асуулт асуух хүн байна уу? Байхгүй бол хурлын дэгийн дагуу Компанийн 2025 оны Үйл ажиллагааны тайланд өгсөн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, Нэр дэвшүүлэх хорооны дарга Б.Гэрлээ танилцуулна.

Б.Гэрлээ: (ТУЗ-ийн гишүүн): Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайланд хийсэн дүгнэлт болох Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 06 дугаар тогтоолыг танилцуулав.

Ц.Зоригтбат(Хуралдаан даргалагч): Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлттэй холбоотой асуулт асуух хувьцаа эзэмшигчийн төлөөлөл байна уу?, санал хэлэх хувьцаа эзэмшигчийн төлөөлөл байна уу? За байхгүй байна, тэгэхээр дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё. Компанийн 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлан Багануур ХК-ийн ерөнхий нягтлан бодогч Б.Наранбаатар танилцуулна

Б.Наранбаатар: Компанийн 2024 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийж, зөрчилгүй буюу эерэг дүгнэлт өгсөн боловч 845.1 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнтэй холбогдуулан аудитын тайлангийн мөрөөр хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, Үндэсний аудитын байгууллагад хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажилласан бөгөөд 2025 оны эцсийн байдлаар уг төлөвлөгөө 85 хувийн биелэлттэй тайлагнагдсан, харин 2025 оны санхүүгийн тайланд хийсэн

аудитын дүгнэлтээр нийт 14.8 тэрбум төгрөгийн зөрчил илэрч, тогтоосон материаллаг түвшнээс давсан тул “хязгаарлалттай дүгнэлт” гарсан. Аудитын дүгнэлтэд дурдсанаар, зөрчлүүдэд авлага тооцоо нийлэхгүй байгаа, худалдан авалтын журмын зөрчил, санхүүгийн программ шинэчлэгдээгүй байдал, зарим хөрөнгийг бүртгэлд тусгаагүй, татварын үлдэгдэл удаан хугацаанд хөдөлгөөнгүй байгаа, гэрээний хэрэгжилт хангагдаагүй зэрэг асуудлууд багтсан. Түүнчлэн аудитын байгууллагаас нэг төлбөрийн акт, гурван албан шаардлага, зургаан зөвлөмжийг өгсөн байна. Үүнд, томилолтын зардалтай холбоотой давхардсан олголтыг буцаан барагдуулах, урт хугацааны авлагыг барагдуулах, тендерийн журмын зөрчлийг арилгах, санхүүгийн программ шинэчлэх, бүртгэлд тусгагдаагүй хөрөнгийг бүртгэх, ашиглагдаж буй хөрөнгийн үнэлгээг шинэчлэх зэрэг асуудлууд багтсан, аудитын мөрөөр компанийн зүгээс тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд төлбөрийн актын ихэнхийг барагдуулж, үлдэгдлийг хугацаанд нь шийдвэрлэхээр ажиллаж байгааг дурдав. Мөн урт хугацааны авлагуудыг барагдуулах чиглэлээр хуулийн байгууллагад шилжүүлэн ажиллаж байгаа бөгөөд тодорхой хэсгийг барагдуулсан байна. Санхүүгийн программ шинэчлэх ажлыг 2026 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Үүнээс гадна зарим зөрчилтэй холбоотойгоор Үндэсний аудитын байгууллагад гомдол гаргасан бөгөөд хэрэв уг асуудлууд нааштайгаар шийдвэрлэгдсэн тохиолдолд нийт зөрчлийн хэмжээ мэдэгдэхүйц буурч, аудитын дүгнэлт “хязгаарлалттай”-гаас “Өөрчлөлтгүй” болж сайжрах боломжтой.

Ц.Зоригтбат (Хуралдаан даргалагч): За аудитын санхүүгийн тайлан танилцуулсан нягтлан бодогч Наранбаатарт баярлалаа. Тэгэхээр энэ дараагийн асуудал компанийн 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг дүгнэлтийг сонсчихоод дараа нь асуулт хариултаа явъя. Иймд дүгнэлтийг ТУЗ-ийн хараат бус гишүүн, аудит, эрсдэлийн хорооны дарга Н.Зоригтсайхан танилцуулна уу

Н.Зоригтсайхан (Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн): Компанийн 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайланд хийсэн дүгнэлт болох Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 07 дугаар тогтоолыг танилцуулав.

Ц.Зоригтбат (Хуралдаан даргалагч): Хувьцаа эзэмшигч нарт компанийн 2025 оны санхүүгийн тайлантай холбогдолтой асуулт, санал байна уу?

Хувьцаа эзэмшигч Э.Шижир: Компанийн санхүүгийн тайлан, үйл ажиллагааны явцын мэдээлэл Төлөөлөн удирдах зөвлөлд тогтмол, бүрэн хүрдэггүй байгааг онцолж, улирлын тайлангуудыг тогтмолжуулан танилцуулдаг тогтолцоог бий болгох шаардлагатай байна. Мөн компанийн бизнес төлөвлөгөө, томоохон шийдвэрүүд Төлөөлөн удирдах зөвлөлөөр урьдчилан хэлэлцэгдэлгүйгээр шууд толгой компанид хүргэгдэж, дараа нь буцаан хэлэлцүүлэх байдлаар явж байгаа нь шийдвэр гаргах үйл явцыг удаашруулж, засаглалын зохистой бүтэц алдагдахад хүргэж байна. Иймд асуудлуудыг эхлээд Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцэж, дараа нь холбогдох түвшинд хүргэх зохистой дарааллыг мөрдүүлэх шаардлагатай байна. Түүнчлэн төрийн төлөөллийг хэрэгжүүлэхтэй холбоотой журмын хэрэгжилт бодит байдал дээр Төлөөлөн удирдах зөвлөлийн

гишүүдийн хараат бус байдал, мэргэжлийн шийдвэр гаргалтад сөргөөр нөлөөлж байгааг шүүмжилж, удирдамжид тулгуурлан санал өгдөг тогтолцоо нь зөв, буруу эсэхээс үл хамааран шийдвэрийг дагах нөхцөл бүрдүүлж, хариуцлагын тогтолцоог сулруулж байгааг онцлов. Иймд зөвхөн тус компанид бус, төрийн өмчит компаниудын хэмжээнд засаглалын энэхүү асуудлыг бодлогын түвшинд анхаарч засах шаардлагатайг дурдав. Мөн компанийн удирдлагын тогтвортой байдал сул, гүйцэтгэх захирлын албан тушаалд удаан хугацаанд үүрэг гүйцэтгэгчээр ажиллуулж байгаа нь сонгон шалгаруулалтын ил тод, нээлттэй байдал хангагдахгүй байгааг илэрхийлж, энэ нь компанийн засаглалд сөргөөр нөлөөлж болзошгүйг тэмдэглэв. Нэмээд аудитын дүгнэлттэй холбоотой асуудлыг хөндөж, аудитын явц, дүгнэлтийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн түвшинд хангалттай мэдээлэл солилцох, хяналт тавих механизм сул байгааг дурдав. Энэ жилийн Аудитын тайлангийн хувьд бодит мөнгөн гүйлгээ хийгдээгүй, зөвхөн гэрээний түвшинд байгаа асуудлаас шалтгаалан аудитын “хязгаарлалттай” дүгнэлт гарч байгаа нь бодит нөхцөл байдалтай нийцэхгүй байж болзошгүйг онцлов.

Иймд дээр дурдсан санхүүгийн ил тод байдал, шийдвэр гаргалтын дараалал, Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус байдал, удирдлагын тогтвортой байдал болон аудитын хяналтын тогтолцоотой холбоотой засаглалын асуудлуудыг цогцоор нь сайжруулах шаардлагатайг санал болгож, эдгээр асуудлууд нь онцгойлон анхаарахыг хүслээ.

Ц.Зоригтбат(Хуралдаан даргалагч): Компанийн 2025 оны санхүүгийн аудитлагдсан тайлантай холбогдолтой асуулт, санал байна уу? За байхгүй байгаа тул хурлын дэгийн дагуу дараагийн хэлэлцэх асуудалд орёе. Компанийн ногдол ашиг хуваарилах эсэх тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг ТУЗ-ийн хараат бус гишүүн, аудит, эрсдэлийн хорооны дарга Н.Зоригтсайхан танилцуулна уу

Н.Зоригтсайхан(Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн): Компанийн хувьцаа эзэмшигч нарт ногдол ашиг хуваарилах эсэх талаар гаргасан Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 03 дугаар тогтоолыг танилцуулав.

Ц.Зоригтбат(Хуралдаан даргалагч): Ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолтой танилцлаа, асуулт асууж, санал хэлэх хүн байна уу?

Ч.Энхтөр (хувьцаа эзэмшигч): Компанийн 2025 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангаар ашигтай ажилласан тохиолдолд ногдол ашиг хуваарилах нь зүйтэй, гэхдээ ногдол ашгийг хуваарилахдаа компанийн өр, зээлийн дарамтыг бууруулахтай уялдуулан ашиглах боломжтой, тухайлбал, “Эрдэнэс Монгол” ХХК-д хүлээсэн өр төлбөрийг ногдол ашгаар суутган барагдуулах байдлаар шийдвэрлэх боломжтой байна, ингэснээр компанийн ашигт ажиллагаа, санхүүгийн сахилга бат сайжрах ач холбогдолтой байна. Яагаад ногдол ашиг хуваарилаагүй талаар нэмэлт тайлбар сонсмоор байна?

Б.Гэрлээ(ТУЗ-ийн гишүүн): Ногдол ашиг нь тухайн жилийн цэвэр ашгаас хуваарилагддаг боловч компанийн хувьд өмнөх онуудаас хуримтлагдсан санхүүгийн алдагдал их байгаа, хэдийгээр 2025 оны санхүүгийн гүйцэтгэлээр

ашигтай ажилласан үзүүлэлттэй гарсан ч өмнөх алдагдлыг бүрэн нөхөөгүй нөхцөлд ногдол ашиг хуваарилах нь санхүүгийн хувьд зохистой бус гэж үзсэн. Түүнчлэн, хэрэв ногдол ашиг хуваарилсан тохиолдолд “Эрдэнэс Монгол” ХХК-д хүлээсэн өр төлбөрийг бууруулахад бодит нөлөө үзүүлэхгүй, харин ногдол ашгийн хэлбэрээр буцаан шилжих боловч компанийн алдагдал хэвээр үлдэх эрсдэлтэй, иймд компанийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах үүднээс эхний ээлжид хуримтлагдсан алдагдлыг нөхөх нь зүйтэй гэж үзэн ногдол ашиг хуваарилахгүй байх шийдвэрийг гаргасан болно.

Хувьцаа эзэмшигч Э.Шижир: Би хувийн хэвшлийн хувьцаа эзэмшигчдийг төлөөлж ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байгаа, миний хувьд ногдол ашиг тараах эсэх асуудлыг хэлэлцэх үед ногдол ашиг хуваарилах шаардлагатай гэсэн саналтайгаар оролцож байсан. Мөн ногдол ашиг нь хувьцаа эзэмшигчдийн компанийн үйл ажиллагаанд оролцсоны үр шимийг хүртэх, орлого олох чухал эх үүсвэр боловч уг ашгийг хуваарилахгүй байгаа нь жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт сөргөөр нөлөөлж байгаа. Түүнчлэн ногдол ашиг хуваарилах боломжгүй нөхцөл байдал нь компанийн борлуулж буй нүүрсний үнийг Эрчим хүчний зохицуулах хорооноос бодит өртгөөс доогуур тогтоож ирсэнтэй л мөн холбоотой. Үүний улмаас компани тогтмол алдагдалтай ажиллаж, өр зээлийн дарамтад орж, улмаар хувьцаа эзэмшигчид ногдол ашгаа хүртэж чадахгүй нөхцөл байдал үүсэж байна. Иймд дээрх нөхцөл байдлыг анхаарч, бодлогын түвшинд шийдвэрлэх шаардлагатай байна.

Ц.Зоригтбат(Хуралдаан даргалагч): За өөр асуулт асууж, санал хэлэх хүн байна уу? Байхгүй бол хурлын дэгийн дагуу Багануур ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн тайлантай танилцъя. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга П.Баттөр дарга танилцуулгаа хийнэ үү

П.Баттөр(ТУЗ-ийн дарга): Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны тайланг танилцуулав. Тайлант хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөл 13 гишүүний бүрэлдэхүүнтэй ажилласан бөгөөд үүнд төрийн төлөөлөл, мэргэжлийн болон хараат бус гишүүд багтсан байна. Энэхүү бүтэц нь шийдвэр гаргалтад тэнцвэртэй, ил тод байдлыг хангахад чухал үүрэгтэй ажилласан гэж дүгнэв. Гишүүд нь уул уурхай, санхүү, эдийн засаг, эрх зүй, төрийн бодлогын чиглэлээр мэргэшсэн туршлагатай байсан бөгөөд хэлэлцсэн асуудалд идэвхтэй оролцож, мэргэжлийн байр сууринаас санал зөвлөмж гаргасан байна. Төлөөлөн удирдах зөвлөл 2025 онд нийт 4 зорилтын хүрээнд 30 арга хэмжээ төлөвлөснөөс 93 хувийн хэрэгжилттэй ажилласан байна. Хэлэлцсэн асуудлууд нь бизнес төлөвлөгөө, төсөв, санхүүгийн тайлан, аудит, ногдол ашиг, санхүүжилт, бүтэц орон тоо, гүйцэтгэх удирдлагын томилгоо, үнэлгээ, хөрөнгийн удирдлага зэрэг үндсэн чиглэлүүдийг хамарсан байна. Шийдвэр гаргалтын ихэнх хувийг санхүү, төсвийн асуудал эзэлсэн бол аудит, хяналт болон удирдлагын томилгоотой холбоотой асуудлууд мөн чухал байр суурь эзэлжээ. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод идэвхтэй ажилласан бөгөөд нэр дэвшүүлэх хороо 5 удаа, аудитын хороо 8 удаа, цалин урамшууллын хороо 3 удаа тус тус хуралдаж, холбогдох асуудлуудаар мэргэжлийн зөвлөмж боловсруулан ТУЗ-ийн шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлсэн байна. Мөн ТУЗ тайлант хугацаанд ТУЗ нийт 30 удаа хуралдаж, 98 хувийн ирцтэй оролцсон нь идэвхтэй үйл ажиллагааг илтгэж байна. Мөн нийт 25 тогтоол, 3 тэмдэглэл баталж, шийдвэрийн хэрэгжилт 83 хувьтай байсан нь гаргасан шийдвэрүүд бодит үр дүнтэй хэрэгжсэнийг харуулж байна. Хурлын давтамж, оролцоо, шийдвэрийн хэрэгжилтийн үзүүлэлтүүд нь олон улсын сайн засаглалын жишигтэй нийцэж байгааг онцлон тэмдэглээд, ерөнхийд нь

дүгнэхэд Төлөөлөн удирдах зөвлөл 2025 онд идэвхтэй, үр дүнтэй ажиллаж, компанийн стратеги, удирдлага, хяналтын чиглэлээр бодитой хувь нэмэр оруулсан байна.

Ц.Зоригтбат(Хуралдаан даргалагч): Багануур ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн тайлантай танилцлаа, тус тайлангаас асуулт асууж, санал хэлэх хүн байна уу?

Хувьцаа эзэмшигч Э.Шижир: Компанийн засаглалтай холбоотой дараах асуудлыг хөндөв. Тэрээр Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн шийдвэр гаргалтад удирдамжтай, удирдамжгүй” гэсэн зохицуулалт нөлөөлж, гишүүдийн бие даасан, мэргэжлийн шийдвэр гаргах боломж хязгаарлагдаж байгааг онцолж байна. Мөн зарим асуудал удирдамжгүйгээс болж огт хэлэлцэгдэхгүй үлдэх, зарим тохиолдолд урьдчилсан чиглэлтэй учир формаль байдлаар батлагдах хандлага байгааг шүүмжилж байна. Мөн ТУЗ-ийн төлөвлөгөөнд туссан ТУЗ-ийн үйл ажиллагааны журам хэлэлцэгдээгүй үлдсэн, ТУЗ-ийн бүтэц, хороодын зохион байгуулалтыг өргөжүүлж, одоо ажиллаж буй 3 хороонд нэмэлтээр стратеги болон хяналтын чиглэлийн хороод байгуулах шаардлагатай байна. Бас гүйцэтгэх удирдлагыг “үүрэг гүйцэтгэгч” статусаас гаргаж, жинхлэх асуудлыг хэлэлцэх ёстой ч бүрэн хэрэгжихгүй байна. Цаашлаад тэрээр төрийн төлөөллийн удирдамжийн тогтолцоог сайжруулах шаардлагатай гэж үзсэн. Удирдамж нь зөвхөн ерөнхий зорилго, чиглэл (орлого нэмэгдүүлэх, зардал бууруулах гэх мэт)-ийг тодорхойлох түвшинд байх ёстой бөгөөд харин өдөр тутмын шийдвэрийг ТУЗ-ийн гишүүд мэргэжлийн мэдлэг, туршлагадаа тулгуурлан бие даан гаргах боломжтой байх ёстой гэж үзэж байна. Ингэснээр ТУЗ-ийн гишүүдийг зөвхөн удирдамжийн дагуу санал өгдөг байдлаар хязгаарлахгүй, харин үр дүн хариуцах хүрээнд нь мэргэжлийн шийдвэр гаргах эрх, боломжийг хангах нь засаглалын зөв зарчимд нийцнэ гэж үзэж байна.

Хувьцаа эзэмшигч М.Отгонбаяр: Компанийн засаглалын өнөөгийн байдал хангалтгүй байгааг онцлон тэмдэглэж, шийдвэр гаргалтын явцад удирдамж авах, материал баталгаажуулах зэрэг зохион байгуулалтын саатал үүсэж байгаа нь компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна. Мөн өмнө нь төрийн өмчийн бодлого, зохицуулалтын байгууллагын үед засаглалын тэнцвэр харьцангуй сайн хангагдаж байсан. Одоогийн тогтолцоонд Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус байдал, мэргэжлийн тэнцвэр сул байна, учир нь өмнөх хугацаанд хараат бус гишүүдийг мэргэжлийн холбоод болон салбарын байгууллагуудаас илүү өргөн хүрээнд оролцуулж, нэр дэвшүүлэх, аудит, цалин урамшууллын хороодын бүрэлдэхүүнд олон талын төлөөллийг хангаж ажилладаг байсан бол одоогийн нөхцөлд энэ тэнцвэр алдагдсан. Түүнчлэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дотоод зохион байгуулалт, шийдвэр гаргалтын үйл явцын уялдаа холбоо сул байгаагаас шалтгаалан материалууд толгой байгууллагын түвшинд 7–21 хоног саатах тохиолдол гарч, шийдвэр гаргалтыг удаашруулж байна. Ерөнхийд нь дүгнэхэд, өнөөгийн тогтолцоонд томоохон хувьцаа эзэмшигчийн нөлөө хэт төвлөрсөн, мэргэжлийн байгууллагын оролцоо сул, хараат бус гишүүдийн оролцооны тэнцвэр алдагдсан байгааг онцлон, Төлөөлөн удирдах зөвлөлийн засаглалыг илүү тэнцвэртэй, хараат бус, мэргэжлийн оролцоонд тулгуурласан байдлаар сайжруулах шаардлагатай байна.

Ц.Зоригтбат(Хуралдаан даргалагч): Багануур ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн тайлангаас асуулт асууж, санал хэлэх хүн байна уу? За байхгүй бол

хурлын дэгийн дагуу дараагийн асуудлыг хэлэлцүүлье. Компанийн өрийг хувьцаагаар солих тухай “Багануур” ХК-ийн Бизнес төлөвлөлтийн хэлтсийн дарга Я.Отгонбаатар танилцуулна.

Я.Отгонбаатар: Өрийг хувьцаагаар солих асуудлын талаар дэлгэрэнгүй танилцуулгад компанийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц, зах зээлийн ханшийн өөрчлөлт болон өр төлбөрийн өнөөгийн байдлыг мэдээлэв. Тус мэдээлэлд компанийн нийт өр 197.8 тэрбум төгрөгт хүрч, сар бүр зээлийн хүүгийн зардал нэмэгдэж байгаа, мөн өрийг хувьцаагаар солих ажиллагааг хэрэгжүүлэхийн өмнө өрийн бүтцийг тодорхойлох, компанийн үнэлгээ хийх, нэгж хувьцааны үнэ тогтоох, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, хуулийн болон зохицуулалтын дүгнэлт гаргах зэрэг шат дараалсан ажил зайлшгүй хийгдэх шаардлагатайг танилцуулж, одоогийн нөхцөлд энэ асуудлыг бүрэн боловсруулж дуусгаагүй тул ээлжит бус хурлаар дахин хэлэлцэж, нарийвчилсан судалгааны үндсэн дээр шийдвэрлэх нь зүйтэй гэсэн санал танилцуулав.

Ц.Зоригтбам(Хуралдаан даргалагч): Өрийг хувьцаагаар солих асуудлын танилцуулгад Засгийн газрын холбогдох шийдвэрүүдийг бүрэн тусгах шаардлагатай байна. Засгийн газраас гаргасан шийдвэрийн дагуу хуримтлагдсан өрийг Эрдэнэс Монгол компанид төвлөрүүлж, улмаар түүнийг хувьцаанд хөрвүүлэх боломжийг судлан шийдвэрлэх чиглэл өгөгдсөн, үүнийг дагуу Багануур болон Шивээ-Овоо зэрэг компаниудад холбогдох судалгааны ажил хийгдэж байгаа. Иймд өнөөдрийн хурлаар уг асуудлыг зөвхөн танилцуулгын түвшинд хэлэлцэж байгаа тул хувьцаа эзэмшигчдийн саналыг сонссоны дараа асуудлыг ээлжит бус хурлаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн компанийн саналыг дэмжиж байна.

Хувьцаа эзэмшигч Э.Шижир: Өрийг хувьцаагаар солих асуудлыг дэмжихгүй байгаа, өрийг хувьцаагаар хөрвүүлэх шийдлийг зохимжгүй гэж үзэв. Өр үүсэх үндсэн шалтгаан нь нүүрсний үнийн зохицуулалтын бодлого болон үнэ тогтоолтын алдаанаас үүдэлтэй тул өрийг хувьцаагаар солих нь одоогийн хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг ноцтой хохироох эрсдэлтэй. Мөн компанийн нийт хувьцааны бүтэц болон нэрлэсэн үнэ дээр үндэслэн өрийг хувьцаанд хөрвүүлбэл нэгж хувьцааны үнэ мэдэгдэхүйц буурч, одоогийн хувьцаа эзэмшигчдийн эзэмшлийн хувь хэмжээ буурах, компанийн өмчийн өгөөж буурах сөрөг үр дагавартайг онцлон тайлбарлав. Иймд уг өрийг хувьцаагаар солих бус, төрөөс шууд зохицуулан шийдвэрлэх буюу өрийг тэглэх (“write-off”) хэлбэрээр шийдэх нь зөв гэж үзэв. Түүнчлэн уг асуудлын талаарх материал урьдчилан тараагдаагүй, хангалттай мэдээлэлгүй нөхцөлд хурлаар шийдвэр гаргах боломжгүй тул өнөөдрийн хурлаар зөвхөн мэдээлэл сонссон байдлаар тэмдэглэж, цаашид хэлэлцэх эсэхийг дахин авч үзэх шаардлагатайг онцлов.

Хувьцаа эзэмшигчийн төлөөлөл: Өрийг хувьцаагаар солихтой санал нийлэхгүй байна, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг хангалтгүй хамгаалагдаж байна. Өрийн асуудал удаан хугацаанд хуримтлагдсан нь иргэд, хувьцаа эзэмшигчдэд шууд дарамт болж байгааг дурдан, энэ нөхцөл байдалд өөрчлөлт хийх шаардлагатай гэж үзэв. Мөн компанийн засаглал болон шийдвэр гаргалтын процесс ил тод бус, мэдээлэл хангалтгүй байгааг шүүмжилж, Эрдэнэс Монгол нэгдэл болон төрийн байгууллагуудын оролцоотой холбоотой

зохицуулалтад зөрчил, давхардал үүсэж байгааг онцолсон. Асуудлыг ээлжит бус хурлаар дахин хэлэлцэхийг дэмжиж байгаагаа илэрхийлэв.

Хувьцаа эзэмшигчийн төлөөлөл: Хэлэлцэж буй асуудлыг компанийн дотоод журмын дагуу зохион байгуулах шаардлагатайг тэмдэглэв. Төлөөлөн удирдах зөвлөлөөс гарсан шийдвэрүүд хувьцаа эзэмшигчдийн хуралд дутуу бэлтгэлтэйгээр орж ирж байгаа нь зохистой биш гэж үзэж, Засгийн газрын шийдвэр болон компанийн хурлын төлөвлөгөө хоорондын уялдаа хангалтгүй байгааг онцлов. Мөн Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн үүрэг, оролцооны талаар тодруулга хүсэж, мэдээлэл ил тод байх ёстойг сануулав.

Л.Ганчимэг(ТУЗ-ийн нарийн бичиг): Тус асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 04 дүгээр тогтоолын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж байгаа. Мөн Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичиг нь хувьцаа эзэмшигчдийн хурлын зохион байгуулалт, холбогдох тогтоол, комиссын шийдвэрийн дагуу мэдээлэл хүргэж ажиллаж байна.

Хувьцаа эзэмшигч Цэдэнсодном: Уурхайчдын болон жижиг хувьцаа эзэмшигчдийн санал, шаардлагыг Төлөөлөн удирдах зөвлөл илүү өндөр түвшинд авч үзэж, шийдвэр гаргалтад тусгах шаардлагатайг онцлон тэмдэглэв. Багануур уурхайн өмнөх үеийн үйл ажиллагаатай холбоотой туршлагаа дурдан, 1998–2002 оны хооронд тус уурхай алдагдалгүй ажиллаж байсан гэж тэмдэглэв. Тэрээр тухайн үеийн төрийн удирдлагын бодлого, зохион байгуулалт харьцангуй тогтвортой байсан гэж үзэж, өнөөгийн нөхцөл байдалтай харьцуулахад засаглал, үнэ тогтоолтын бодлогын зөрүү их байгааг онцолсон. Мөн нүүрсний үнийн зохицуулалт болон уурхайн техник, технологийн шинэчлэл нь компанийн тогтвортой ажиллагаанд чухал нөлөөтэйг анхаараарай.

Хувьцаа эзэмшигчийн төлөөлөл: Өрийг хувьцаагаар солих асуудлын хувьд шинээр хувьцаа гаргах тохиолдолд зах зээл дээрх хүлээн зөвшөөрөгдөх байдал, үнэлгээний бодит байдал чухал болохыг онцлов. Тэрээр нэмэлт хувьцаа гаргах замаар өрийг шийдвэрлэх хувилбарын эрсдэлийг дурдан, зах зээл дээр үнэ унах, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт сөргөөр нөлөөлөх боломжтой гэж үзэв. Мөн компанийн санхүүгийн мэдээлэл илүү тодорхой, нэгтгэсэн байдлаар танилцуулагдах шаардлагатайг онцолж, өрийн хэмжээ, хувьцааны үнэлгээ, хөрөнгийн бүтэц зэрэг үзүүлэлтүүдийг нэгдсэн байдлаар ойлгомжтой гаргах хэрэгтэйг санал болгов. Түүнчлэн өрийг хувьцаагаар солих ажиллагаанд үнэлгээний аргачлал тодорхой байх шаардлагатайг тэмдэглэж, дансны үнэ, зах зээлийн үнэ болон бодит үнэлгээний ялгааг нарийвчлан авч үзэх хэрэгтэй гэж үзэв. Мөн энгийн хувьцааны тоо хэмжээ, бүтэц өөрчлөгдөх нь хувьцаа эзэмшигчдийн эрхэд шууд нөлөөлөх тул нарийн тооцоо, судалгаанд тулгуурлах ёстойг онцолсон. Энэ асуудал нь нарийн тооцоо, үнэлгээ шаардсан тул өнөөдрийн хурлаар эцэслэн шийдвэрлэх боломжгүй, дараагийн ээлжит хурлаар илүү боловсруулсан хэлбэрээр хэлэлцэх нь зүйтэй гэсэн байр суурийг дэмжиж байгаагаа илэрхийлэв.

Хувьцаа эзэмшигчийн төлөөлөл: Зах зээл дээр хувьцааны үнийг хэт өндөр тогтоовол худалдан авах сонирхол буурч болзошгүйг дурдсан бөгөөд харин

боломжит үнэлгээгээр гаргавал хөрөнгө оруулагч татах боломжтой гэж гэсэн санал гаргав.

Хувьцаа эзэмшигчийн төлөөлөл: Өрийн хэмжээг тодруулж, нийт дүн болон “өрийг хувьцаагаар солих” ажиллагааны мөн чанарыг дахин лавласан бөгөөд энэ нь шинэ өр нэмэх бус одоо байгаа өрийг хувьцаанд хөрвүүлэх ажиллагаа гэж ойлгож байгаа зөв үү?

Хувьцаа эзэмшигч Э.Шижир: Энэхүү хөрвүүлэлт нь голчлон Эрдэнэс Монгол компанид хамаарах 197 тэрбум төгрөгийн өртэй холбоотой бөгөөд энэ хэмжээгээр хувьцаа шинээр бүртгэгдэх нь одоогийн хувьцаа эзэмшигчдийн эзэмшлийн хувь хэмжээг мэдэгдэхүйц бууруулах эрсдэлтэйг анхааруулав.

Ц.Зоригтбат (Хуралдаан даргалагч): Засгийн газрын шийдвэрийн хүрээнд уг ажил явагдаж байгаа бөгөөд энэ нь зөвхөн мэдээллийн шинжтэй танилцуулга болохыг онцолж, цаашид мэргэжлийн байгууллагууд оролцсон нарийвчилсан үнэлгээ хийгдэж байж хувьцааны үнэ, нөлөөллийг тодорхой болгох шаардлагатай гэж мэдэгдэв. Иймээс уг асуудлыг дараагийн хурлаар дахин нарийвчлан хэлэлцэхээр хойшлуулах нь зүйтэй гэж үзэв.

Алтансүх): Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн болон хувьцаа эзэмшигчдийн төлөөллийн шаардлагын талаар асуулт тавьж, өрийг хувьцаагаар солих хөтөлбөрт ТУЗ ямар байр суурьтай байгааг тодрууллаа.

Хувьцаа эзэмшигч Э.Шижир: Хувьцаа эзэмшигчид “том, жижиг” гэж ялгаварлагдахгүй, нэгж хувьцааны эрх тэгш байдлаар оролцдог. Гэвч шийдвэр гаргах эрхийн түвшин ялгаатай байдаг. Компанийн өнөөгийн нийт хувь нийлүүлсэн хөрөнгө ойролцоогоор 2 тэрбум төгрөг бөгөөд Засгийн газраас гарч буй шийдвэрийн дагуу их хэмжээний өрийг хувьцаанд хөрвүүлэх нь одоогийн хувьцаа эзэмшигчдийн эзэмшлийн хувийг мэдэгдэхүйц (5, түүнээс ч дээш дахин) бууруулах эрсдэлтэй байна. Мөн өр үүссэн үндсэн шалтгаан нь компанийн хяналтаас гадуур, бүтээгдэхүүний үнийг өртгөөс доогуур тогтоосон бодлоготой холбоотой. Ийм нөхцөлд өрийг хувьцаагаар шууд хөрвүүлэх нь шударга бус гэж үзэж, харин өрийг төрөөс шийдвэрлэж (тэглэх эсвэл өөр хэлбэрийн зохицуулалт хийх) үндсэн асуудлыг шийдэх ёстой гэсэн байр суурьтай байна. Мөн эрчим хүчний салбарт татаас болон үнийн зохицуулалт тусгай механизмаар шийдэгддэг бол нүүрсний салбарт ийм зохицуулалт дутмаг байгаа нь өр хуримтлагдах нэг шалтгаан болсон.

Т.Отгонболд (Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч): Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогчдод талархал илэрхийлж, Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, хараат бус гишүүд болон жижиг хувьцаа эзэмшигчдийн төлөөллийн талаар танилцуулга хийв. Мөн хувьцаа эзэмшигчдийг компанийн үйл ажиллагаанд чухал оролцоотой тал гэж үзэж байгаагаа онцлов. Өрийг хувьцаагаар солих асуудал нь зөвхөн компанийн дотоод шийдвэр бус, Засгийн газрын тогтоол болон бодлогын түвшний шийдвэртэй уялдаж явагдаж буйг тодотгов. Энэ хүрээнд төрийн өмчит компаниудын өрийг хувьцаанд хөрвүүлэх чиглэл бүхий Засгийн газрын тогтоол, мөн холбогдох хуулийн хэлэлцүүлэг явагдаж байгааг дурдав. Компанийн зүгээс уг асуудлыг мэргэжлийн зөвлөх байгууллага, хөрөнгийн биржид бүртгэлтэй оператор компанитай хамтран судалж

байгаа бөгөөд хуулийн болон санхүүгийн нарийвчилсан тооцоо, аргачлал боловсруулах шатанд байгааг мэдээлэв. Мөн Гүйцэтгэх удирдлагын зүгээс уг ажил нь өндөр ач холбогдолтой, нарийн тооцоолол шаардсан тул шууд хэрэгжүүлэх боломжгүй бөгөөд үе шаттай, судалгаанд суурилсан байдлаар хэрэгжихийг онцлов. Мөн өрийг хувьцаагаар солих шийдэл нь компанийн санхүүгийн тогтвортой байдлыг сайжруулах, ашигт ажиллагааг хангах зорилготойг дурдсан.

Хувьцаа эзэмшигч Э.Шижир: Уг ажил бодитоор хэрэгжиж эхэлсэн үү?

Т.Отгонболд (Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч): Албан ёсоор эхлүүлээгүй, зөвхөн судалгааны ажил хийгдэж байна.

Хувьцаа эзэмшигчийн төлөөлөл: Өрийг хувьцаагаар солих асуудлыг бүх хувьцаа эзэмшигчдэд хамгийн оновчтой байдлаар шийдвэрлэх шаардлагатай гэж үзэв. Нэмэлт хувьцаа гаргах тохиолдолд шинэ ангиллын хувьцаа гаргах (жишээ нь “Багануур II” гэх мэт) хэлбэрээр шийдэх боломжтой гэж санал гаргав. Ингэснээр одоогийн хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг шууд хохирохгүй, зах зээл дээр шинэ хөрөнгө оруулагч татах боломж бүрдэхийг онцлов.

Хувьцаа эзэмшигчийн төлөөлөл: Нэг компанид олон төрлийн хувьцаа гаргах боломжийн талаар дурдав. Гэхдээ энэ нь биржийн зохицуулалт, практикт нийцэж байгаа эсэхийг анхаарах шаардлагатайг тэмдэглэв.

Ц.Зоригтбат (Хуралдаан даргалагч): Хувьцаа эзэмшигчдийн саналыг нэгтгэн авч үзэх, цаашид компанид судалгаанд суурилсан байдлаар хүргүүлэх шаардлагатайг онцлов. Мөн бүх хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг тэнцвэртэй хангах нь Эрдэнэс Монгол компанийн үндсэн зарчим болохыг тайлбарлав.

Хувьцаа эзэмшигч Э.Шижир: Өрийг хувьцаагаар солих нь одоогийн хувьцаа эзэмшигчдийн эзэмшлийн хувь хэмжээг бууруулах эрсдэлтэй гэж үзэв. Өр үүсэх үндсэн шалтгаан нь төрөөс тогтоосон үнэ, бодлоготой холбоотой тул тухайн өрийг хувьцаагаар хөрвүүлэх бус, төрөөс шийдвэрлэх нь зүйтэй гэж байр сууриа дахин илэрхийлэв.

Ц.Зоригтбат (Хуралдаан даргалагч): За хэлэлцэж буй асуудалтай холбоотой өөр саналтай хүн байна уу? За байхгүй бол дараагийн асуудал нь дүрмийн өөрчлөлтийн асуудал байна. Тус асуудлыг өрийг хувьцаагаар солих асуудлаас хамаарч хэлэлцэх байсан уу?

Я.Отгонбаатар: тус асуудал нь ямар нэгэн шийдвэр гарахгүй хойшилсон тул Дүрмийн өөрчлөлттэй холбоотой асуудлыг мөн өнөөдрийн хурлаар хэлэлцэгдэхгүй.

Ц.Зоригтбат (Хуралдаан даргалагч) Үүн дээр саналтай хүн байна уу? За байхгүй бол хурлын дэгийн дагуу дараагийн асуудлыг хэлэлцье.

Б.Гэрлээ: Түрүүн хувьцаа эзэмшигчдийн зүгээс хөндөгдөж байсан ТУЗ-ийн бүтцийн асуудлаар нэмэлт мэдээлэл өгье. Төлөөлөн удирдах зөвлөл нь Аудит, эрсдэлийн удирдлагын хороо, Засаглал, нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороо гэсэн 3 хороотойгоор үйл ажиллагаа явуулж байгаа. Цалин урамшууллын хороо, аудитын хороог хараат бус гишүүн ахалж ажилладаг, Нэр дэвшүүлэх хорооны хувьд Компанийн тухай хуулиараа хараат бус гишүүдийг сонгон шалгаруулдаг тул хараат бус гишүүн ахлах боломжгүй байдаг ч бүтцийг нь

хараат бус гишүүд бүрдүүлдэг, энэ нь хуулийн шаардлагын дагуу бүтэц бүрдсэн. Түрүүн мөн хувьцаа эзэмшигч Отгонбаяр гуайн хэлсэнд нэмэлт тайлбар өгөхөд, хараат бус гишүүдийг компанийн тухай хууль, Засгийн газрын 2023 оны 85 дугаар тогтоолын дагуу нээлттэй сонгон шалгаруулж байгаа бөгөөд сонгон шалгаруулалтад оролцсон хүмүүсээс сонгон шалгаруулж байгаа, төрийн бус байгууллага, холбоодоос ТУЗ-ийн хараат бус гишүүнээр ажиллах хүсэлтээ ирүүлээгүй бол сонголт хийх боломж бүрдэхгүй, харин ТУЗ-ийн ердийн гишүүдийг мэргэжлийн яамдаас мэргэшсэн мэргэжилтнүүдээс бүрдүүлэх бодлого барьж байгаа.

Ц.Зоригтбат (Хуралдаан даргалагч) За дараагийн хэлэлцэх асуудал болох Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай танилцуулгыг Засаглал, нэр дэвшүүлэх хорооны дарга Б.Гэрэлээ танилцуулна уу

Б.Гэрлээ: Нэр дэвшүүлэх хорооноос хараат бус гишүүдийн тайлан, оролцоо, ирц, мэргэжлийн хувь нэмэр, засаглалын үзүүлэлт, санхүү болон эрсдэлийн удирдлагад оруулсан хувь нэмрийг үндэслэн үнэлгээ хийсэн бөгөөд ашиг сонирхлын зөрчил тогтоогдоогүй гэж дүгнэсэн болохыг танилцуулж, компанийн тогтвортой байдал, засаглалын залгамж чанарыг хангах зорилгоор одоогийн хараат бус гишүүдийг улируулан ажиллуулах саналыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулах шийдвэр гаргасныг танилцуулав.

Хувьцаа эзэмшигчийн төлөөлөл: Улираан сонгож байгаа хараат бус гишүүдтэйгээ танилцмаар байна, мэдээлэл өгнө үү

Ц.Зоригтбат (Хуралдаан даргалагч): Хурлын материал, танилцуулгыг дэлгэц дээр ил тод харуулах, мэдээллийг бүрэн хүргээрэй, хараат бус гишүүд өөрсдийгөө танилцуулна уу

Н.Зоригтсайхан (Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн): Би 2005 онд ШУТИС-ийн Уул уурхайн инженерийн сургуулийг төгссөн, уул уурхайн салбарт тасралтгүй ажилласан, Австралид мэргэжил дээшлүүлж магистрын зэрэг хамгаалсан, 2016 оноос хойш докторын түвшинд судалгааны ажил эрхэлж байгаа. Инженерийн туршлага, мэдлэг чадвараа салбарын технологийн хөгжилд оруулах хүсэл эрмэлзэлтэй бөгөөд тэр хүсэл зорилгоороо тус компанийн хараат бус гишүүнээр ажиллаж байгаа болно.

Д.Энхжаргал (Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн): Банк санхүүгийн салбарт 30 орчим жил ажилласан туршлагатай, Монголбанк болон олон улсын байгууллагад удирдах болон зөвлөх түвшинд ажиллаж байсан талаар мэдээлэв. Мөн Эрдэнэс Монголд хараат бус гишүүнээр ажиллаж байсан, аудитын хорооны даргын үүрэг гүйцэтгэж байсан, эрдэс баялгийн салбарын эмэгтэйчүүдийн манлайллыг дэмжих чиглэлээр төсөл, санаачилга хэрэгжүүлж ирснээ танилцуулж, Оксфордын их сургуулийн сертификат, эдийн засгийн хөгжлийн магистрын зэрэг, докторын судалгааны туршлагатай, Багануур ХК-ийн хараат бус гишүүнээр томилогдсоноос хойш ТУЗ болон хороодын хурлуудад бүрэн оролцож ирсэн, компанийн өрийн бүтцийг сайжруулах, засаглал, эрсдэлийн удирдлагыг боловсронгуй болгох, стратегийн түвшний шинэ хорооны бүтэц бий болгох зэрэг санал, зөвлөмжүүд гаргасан талаар мэдээлэв. Тэрээр аудитын хороог эрсдэлийн удирдлагатай нэгтгэн сайжруулах, нэр дэвшүүлэх хороог олон улсын жишгийн

дагуу хөгжүүлэх санал дэвшүүлсэн бөгөөд цаашид үргэлжлүүлэн ажиллах хүсэлтэй, мэргэжлийн мэдлэг, туршлагаа компанийн үр ашгийг нэмэгдүүлэхэд бүрэн зориулахад бэлэн байна.

Ө.Гэрэлт-Од (Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн): 1993 онд Монгол Улсын Их Сургуулийг эдийн засагч мэргэжлээр төгсөж, банкны салбарт ажилласны дараа 2000 оноос МУИС-ийн Бизнесийн сургуульд багш, санхүүгийн тэнхимийн эрхлэгчээр ажиллаж байгаа. Мөн мэргэшсэн нягтлан бодогч, бизнес үнэлгээний мэргэжлийн эрхтэй. Түүнчлэн уул уурхайн салбар болон төрийн өмчит компаниудын техник, эдийн засгийн үнэлгээ, санхүүгийн шинжилгээ, эксперт үнэлгээний ажилд оролцож байсан туршлагатай бөгөөд Эрдэнэс Монгол болон бусад уул уурхайн төслүүдийн хүрээнд ажиллаж байснаа онцлов. Багануур ХК-ийн ТУЗ-д хараат бус гишүүнээр ажиллах хугацаандаа жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, хувьцааны үнэ цэнийг тогтвортой байлгах, ногдол ашиг хүртээмжийг сайжруулах, санхүүгийн үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр санал, зөвлөмж өгч ажилласан гэж мэдээлэв. Би Аудит, эрсдэлийн хорооны гишүүнээр ажиллаж, ТУЗ-ийн хурлуудад бүрэн ирцтэй оролцсон, удирдлагаас өгсөн чиг үүргийн дагуу үнэлгээ, томилолтын ажлуудад оролцож ирсэн талаар дурдаж ирээдүйд үргэлжлүүлэн ажиллах хүсэлтэй байгаа болно.

Б.Гэрлээ: Хоёр хараат бус гишүүн томилолттой байгаа тул тэдний талаарх танилцуулгыг зургийг дэлгэцэд харуулж, товч танилцуулга хийе. С.Цолмон гишүүн нь АНУ-ын их сургуулиудад компьютер мэдээллийн систем болон санхүү, менежментийн чиглэлээр суралцаж, бизнесийн удирдлагын магистрын зэрэг хамгаалсан, Сангийн яам болон хувийн хэвшлийн байгууллагуудад ерөнхий менежер, санхүүгийн захирлаар ажиллаж байсан туршлагатай. Мөн түүний ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хороонд ажилладаг.

Дараагийн гишүүн Б.Даваатогтох гишүүнийг эрх зүйч мэргэжилтэй, нийтийн удирдлага, эрх зүйн магистрын зэрэгтэй, хэвлэл мэдээлэл, төрийн байгууллага болон Монголбанк, аудитын байгууллагад удирдах албан тушаал хашиж байсан туршлагатай гэж танилцуулсан. Тэрээр цалин, урамшууллын хороонд ажилладаг.

Хараат бус гишүүдийн өнгөрсөн жилийн үйл ажиллагааны тайланг хэвлэн хувьцаа эзэмшигчид танилцаарай, хэвлэсэн байгаа.

Ц.Зоригтбат (Хуралдаан даргалагч): Хэлэлцэгдэж буй асуудалтай асуулттай хүн байна уу?

Хувьцаа эзэмшигчийн төлөөлөл: Компанийн засаглалын үнэлгээ 2025 онд 84.7 хувьтай байсан байна, 2024 онд 76.4 хувь байсан байна. Энэ үзүүлэлт одоо буурсан байх гэж таамаглаж байна. Тус компани нь Компанийн тухай хуулийн дагуу нээлттэй, төрийн өмчийн давамгайл оролцоотой байх ёстой боловч бодит байдал дээр засаглал, хурлын үйл ажиллагаа болон бүтэц зохион байгуулалт нь төвлөрсөн шинжтэй болж “нийгэмчлэгдсэн” байна. Мөн хувьцаа эзэмшигчдийн саналын эрх бодитоор хэрэгжихгүй, сонгон шалгаруулалт болон санал хураалтын зарчим алдагдсан гэж бодож байна. Түүнчлэн Төлөөлөн удирдах зөвлөлийн цалин, урамшууллын асуудал ил тод бус, зарим зардал менежментийн гэрээний хүрээнд шингэсэн байж болзошгүй гэж хардаж байна. Төлөөлөн удирдах

зөвлөлийн нарийн бичгийн даргын хараат бус байдал хангагдахгүй байна, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын орон тоогоо Багануур ХК-д нь өгөх хэрэгтэй гэж би бодож байна.

Ц.Зоригтбат (Хуралдаан даргалагч): Хурлын дэгийг нийт хуралд оролцогчдод сануулж байна, хэлэлцэгдэж буй асуудалтай асуулттай хүн байна уу, ТУЗ-ийн гишүүдийг сонгох асуудалтай холбоотой мэдээллийг дэлгэцэд харуулсан байна. Та бүхэн мэдээлэлтэй танилцаад саналаа өгөх юм байна шүү. Тооллогын комисс хувьцаа эзэмшигчдэд саналын хуудас тараасан байгаа юм байна.

Б.Хажидмаа (Тооллогын комиссын дарга): Саналын хуудсыг хэрхэн бөглөх зааварчилгааг өгөв.

Ц.Зоригтбат (Хуралдаан даргалагч): Хурлын хөтөлбөрийн дагуу одоо хувьцаа эзэмшигчдэд тараасан байгаа хэлэлцэх асуудал бүрээр тараасан Хурлын тогтоолууд болон ТУЗ-ийн гишүүдийг сонгох дэлгэцэд өгсөн мэдээллийг харан саналаа өгөх зорилгоор хурал 20 минут завсарлаж байна.

Ц.Зоригтбат (Хуралдаан даргалагч): Хурлын завсарлага дууслаа, хувьцаа эзэмшигчид бүгд саналаа өгч дууссан уу? Саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар авсан санал хураалтын дүнг Тооллогын комиссын дарга Б.Хажидмаа танилцуулна уу

Б.Хажидмаа (Тооллогын комиссын дарга):

1. “Багануур” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоол, дугаар 2, “Санал хураалтын дүнгийн тухай”

Багануур ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирвэл зохих 20,974,360 ширхэг саналын эрх бүхий хувь нийлүүлэгчдээс 20,149,968 ширхэг саналын эрх бүхий хувь нийлүүлэгч оролцож, 16 ширхэг саналын хуудсаар саналаа өгсөн байна.

Хүчингүй саналын хуудас, санал өгөөгүй хуудас байхгүй.

Санал өгсөн байдлыг үзвэл:

Компанийн 2025 оны үйл ажиллагааны талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай.

Зөвшөөрсөн - 20,149,808.00 санал – 99.999%

Татгалзсан – 160.00 санал – 0.001%

Түдгэлзсэн – санал байхгүй – 0.00%

2. “Багануур” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоол, дугаар 3, “Санал хураалтын дүнгийн тухай”

Багануур ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирвэл зохих 20,974,360 ширхэг саналын эрх бүхий хувь нийлүүлэгчдээс 20,149,968 ширхэг саналын эрх бүхий хувь нийлүүлэгч оролцож, 16 ширхэг саналын хуудсаар саналаа өгсөн байна.

Хүчинтэй саналын хуудас, санал өгөөгүй байхгүй.

Санал өгсөн байдлыг үзвэл:

Компанийн 2025 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай.

Зөвшөөрсөн – 20,149,808 санал – 99.999%

Татгалзсан – 160 санал – 0.001%

Түдгэлзсэн – санал байхгүй – 0.00%

3. “Багануур” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоол, дугаар 4, “Санал хураалтын дүнгийн тухай”

Багануур ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирвэл зохих 20,974,360 ширхэг саналын эрх бүхий хувь нийлүүлэгчдээс 20,149,968 ширхэг саналын эрх бүхий хувь нийлүүлэгч оролцож, 16 ширхэг саналын хуудсаар саналаа өгсөн байна.

Хүчинтэй саналын хуудас, санал өгөөгүй байхгүй.

Санал өгсөн байдлыг үзвэл:

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025-2026 оны үйл ажиллагааны тайлангийн танилцуулга

Зөвшөөрсөн – 20,149,808 санал – 99.999%

Татгалзсан – 160. санал – 0.001%

Түдгэлзсэн – санал байхгүй – 0.00%

4. “Багануур” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоол, дугаар 5, “Санал хураалтын дүнгийн тухай”

Багануур ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирвэл зохих 20,974,360 ширхэг саналын эрх бүхий хувь нийлүүлэгчдээс 20,149,968 ширхэг саналын эрх бүхий хувь нийлүүлэгч оролцож, 16 ширхэг саналын хуудсаар саналаа өгсөн байна.

Хүчинтэй саналын хуудас, санал өгөөгүй байхгүй.

Санал өгсөн байдлыг үзвэл:

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай

Зөвшөөрсөн – 20,149,808.00 санал – 99.999%

Татгалзсан – 160.00 санал – 0.001%

Түдгэлзсэн – санал байхгүй – 0.00%

5. “Багануур” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоол, дугаар 6, “Санал хураалтын дүнгийн тухай”

Багануур ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирвэл зохих 20,974,360 ширхэг саналын эрх бүхий хувь нийлүүлэгчдээс 20,149,968 ширхэг саналын эрх бүхий хувь нийлүүлэгч оролцож, 16 ширхэг саналын хуудсаар саналаа өгсөн байна.

Хүчинтэй саналын хуудас, санал өгөөгүй байхгүй.

Санал өгсөн байдлыг үзвэл:

Компанийн өрийг хувьцаагаар солих тухай

Зөвшөөрсөн – 15,732,870.00 санал – 78.079%

Татгалзсан – 4,416,969.00 санал – 21.920%

Түдгэлзсэн – 129.00 санал – 0.001%

6. “Багануур” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоол, дугаар 7, “Санал хураалтын дүнгийн тухай”

Багануур ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирвэл зохих 20,974,360 ширхэг саналын эрх бүхий хувь нийлүүлэгчдээс 20,149,968 ширхэг саналын эрх бүхий хувь нийлүүлэгч оролцож, 16 ширхэг саналын хуудсаар саналаа өгсөн байна.

Хүчинтэй саналын хуудас, санал өгөөгүй байхгүй.

Санал өгсөн байдлыг үзвэл:

Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай

Зөвшөөрсөн – 15,732,999.00 санал – 78.08%

Татгалзсан – 4,416,969.00 санал – 21.92%

Түдгэлзсэн – санал байхгүй – 0.00%

7. “Багануур” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоол, дугаар 8, “ТУЗ-ийн ердийн гишүүдийг сонгох санал хураалтын дүнгийн тухай”

Багануур ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирвэл зохих 20,974,360 ширхэг хувьцаа бүхий 272,666,680 саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдээс 20,149,968 ширхэг хувьцаа бүхий 261,949,584 саналын эрхтэй хувьцаа эзэмшигч оролцсон байна. Үүнээс ТУЗ-ийн гишүүдийг сонгох кумулятив аргаар нийт саналын эрхийн 61.5%-аар ердийн гишүүдийг сонгох санал хураалт явуулж 16 ширхэг саналын хуудсаар саналаа өгсөн байна. /Санал хураалтын нэгдсэн дүнг хавсаргав/

Хүчинтэй саналын хуудас, санал өгөөгүй байхгүй.

Санал өгсөн байдлыг үзвэл:

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд дараах нэр бүхий ердийн гишүүдийг сонгогдсонд тооцсугай.

Санал хураалтын дүн:

1. П.Баттөр – 20,975,736.0 санал
2. Б.Батцэцэг – 20,975,736.0 санал
3. Э.Дэлгэр – 20,975,736.0 санал
4. Б.Баярдаваа – 20,975,736.0 санал
5. Д.Жавзансүрэн – 20,975,736.0 санал
6. Г.Нямсүрэн – 20,975,736.0 санал
7. М.Отгонбаяр – 17,674,333.0 санал
8. Э.Шижир – 17,672,498.0 санал

“Багануур” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоол, дугаар 9, “ТУЗ-ийн хараат бус гишүүдийг сонгох санал хураалтын дүнгийн тухай”

Багануур ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирвэл зохих 20,974,360 ширхэг хувьцаа бүхий 272,666,680 саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдээс 20,149,968 ширхэг хувьцаа бүхий 261,949,584 саналын эрхтэй хувьцаа эзэмшигч оролцсон байна. Үүнээс ТУЗ-ийн гишүүдийг сонгох кумулятив аргаар нийт саналын эрхийн 38.5%-аар хараат бус гишүүдийг сонгох санал хураалт явуулж 16 ширхэг саналын хуудсаар саналаа өгсөн байна. /Санал хураалтын нэгдсэн дүнг хавсаргав/

Хүчинтэй саналын хуудас, санал өгөөгүй байхгүй.

Санал өгсөн байдлыг үзвэл:

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд дараах нэр бүхий хараат бус гишүүдийг сонгогдсонд тооцсугай.

Санал хураалтын дүн:

1. Б.Гэрэлт-Од – 37,817,988.0 санал
2. Д.Энхжаргал – 15,733,581.0 санал
3. Н.Зоригтсайхан – 15,732,376.0 санал
4. С.Цолмон – 15,732,246.0 санал
5. Б.Даваатогтох – 15,732,146.0 санал

ТООЛЛОГЫН КОМИСС:

Дарга:	Б.Хажидмаа
Гишүүд:	М.Дондогдулам
	Б.Наранцэцэг

Ц.Зоригтбат (Хуралдаан даргалагч): Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоолыг бүгд сонслоо, тус комиссын тогтоолд үндэслэн дараах тогтоолууд гарч байна, Тогтоол бүрийг уншиж танилцуулав.

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай
2. Компанийн 2025 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай
3. Компанийн өр төлбөрийг шийдвэрлэх асуудлыг нэмэлтээр судалж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцүүлэх тухай
4. “Багануур” ХК-ийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хойшлуулах тухай
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай

Ц.Зоригтбат (Хуралдаан даргалагч): Тогтоолуудын утга, найруулга дээр санал байна уу? Тогтоол дээр найруулга, өөрчлөлтийн санал байхгүй бол тогтоолууд батлагдсанд тооцлоо.

Багануур ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хэлэлцэхээр төлөвлөсөн асуудлуудаа хэлэлцэж дууслаа. Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн хуралд хүрэлцэн ирсэн нийт хувьцаа эзэмшигчдэдээ талархлаа. Цаашид компанийн үйл ажиллагааг сайжруулах, компанийн өр төлбөрийг бууруулах чиглэлээр үнэтэй

саналаа хуваалцсан хувьцаа эзэмшигчдийнхээ саналыг хэрэгжүүлэх чиглэлээр Эрдэнэс Монгол компани, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын баг хамтран ажиллана. Түүнчлэн компаниа нийт хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт нийцүүлж, ашигтай ажилладаг компани болох чиглэлээр ажиллах ёстой гэж үзэж байгаа. Иймд бүгдээрээ энэ зорилгын төлөө бүгдээрээ хамтраад ажиллая аа. Тэгээд та бүхний ажил амьдралд сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн хурал дууссаныг мэдэгдье ээ. Баярлалаа та бүхэндээ.

ХУРАЛ ДАРГАЛАГЧ :

 Ц.ЗОРИГТБАТ

Тэмдэглэл хөтөлсөн:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга



Л.Ганчимэг